



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ноён сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ӨМА-2022/08/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Даланзадгад хот 2023 он</p>	<p>Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaaja@audit.gov.mn Аудитор: Ө.Болортуяа Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.03.25 № 314
танай _____-ны № _____-т

НОЁН СУМЫН ЗАСАГ ДАРГА
О.НАСАНБУЯН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ноён сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархсан гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ноён сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг журамд заагаагүй арга хэмжээнд зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсөл, хөтөлбөрийн зардлаас нэг төрийн албан хаагчид давхардуулан дэмжлэг олгосон 69,111.8 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 1,323,953.9 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 2,229,466.4 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

016020547

Аудитын гол асуудал

Сумын түүхт 100 жилийн ойгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас олгосон хандив тусламж болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгаснаар бараа материал 585,674.3 мянга, үндсэн хөрөнгө 2,151,867.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Бусад асуудлыг хэсэг

Төрийн үйлчилгээний чанар хүртээмж, бүтээмжийг нэмэгдүүлэхээр чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 стандартыг хэрэгжүүлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		3,211,916.80	3,038,136.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,063,762.00	815,544.50
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	219,548.50	477,470.20
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б		
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	329479.7	903,908.00
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	1,599,126.60	841,213.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,306,311.70	11,458,487.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,306,311.70	11,458,487.20
39200	Биет хөрөнгө		9,157,972.00	11,310,938.80
39300	Биет бус хөрөнгө	13	148,339.60	147,548.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		12,518,228.50	14,496,623.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,460,338.00	6,182,700.50
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	600,517.00	637,264.90
41300	Өглөг	17а, 17б	600,517.00	637,264.90
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,859,821.00	5,545,435.70
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	4,859,821.00	5,545,435.70
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,057,890.50	8,313,922.60
51	Засгийн газрын хувь оролцоо		7,057,890.50	8,313,922.60
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,546,736.00	1,546,736.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		19,946.00	19,946.00
51200	Хуримтлагдсан үр дүн		5,340,030.80	6,596,062.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		151,177.70	151,177.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		12,518,228.50	14,496,623.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,674,716.90	9,183,758.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО		539,671.40	2,006,256.20
110	Орлогын албан татвар		192,327.60	1,128,245.40
1100	Хувь хүний орлогын албан татвар		202,280.00	1,143,216.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-9952.4	-14,971.40
113	Хөрөнгийн албан татвар		39,598.30	45,786.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		307,745.50	832,224.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,715,435.60	3,052,432.20
120	Нийтлэг татварын бус орлого		1,715,435.60	3,052,432.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,419,609.90	4,125,069.60
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	6,631,500.30	7,927,725.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ		6,631,500.30	7,927,725.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,106,250.60	5,563,809.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		240,062.40	394,184.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		30,028.80	50,469.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		268,888.40	102,177.20
2104	Хангамж, бараа материалын зардал		88,908.60	404,927.80
2105	Нормативт зардал			100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		76,828.00	58,904.40
2107	Томилолт, зочны зардал		6,242.00	8,940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		244,616.10	571,384.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		3,150,676.30	3,972,721.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,525,249.80	2,363,916.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		43,216.60	1,256,032.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		5,881,547.10	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-5,838,330.60	1,256,032.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	12,883,758.60	12,883,758.60
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,462.40	12,462.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,896,221.00	12,896,221.00
9	Тайлант үеийн үр дүн	-5,838,330.60	-5,838,330.60
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,057,890.50	7,057,890.50
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,057,890.50	7,057,890.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,057,890.50	7,057,890.50
19	Тайлант үеийн үр дүн	1,256,032.10	1,256,032.10
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,313,922.60	8,313,922.60

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,585,642.20	7,123,135.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	539,671.40	2,006,256.20
110	Орлогын албан татвар	192,327.60	1,128,245.40
1100	Хувь хүний орлогын албан татвар	202,280.00	1,143,216.70
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-9,952.40	-14,971.40
113	Хөрөнгийн албан татвар	39,598.30	45,786.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	307,745.50	832,224.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,109.70	11,190.00
1181	Газрын төлбөр	234,978.20	683,453.20
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	53657.5	137,581.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	626,360.80	991,809.10
120	Нийтлэг татварын бус орлого	626,360.80	991,809.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,419,609.90	4,125,069.60
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,378,400.20	6,299,419.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,378,400.20	6,299,419.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,747,467.70	4,738,584.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	366,994.80	572,217.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,382.60	104,065.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	324,186.30	120,212.00
2104	Хангамж, бараа материалын зардал	198,726.60	288,670.40
2105	Нормативт зардал	200.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	72,878.00	58,859.40
2107	Томилолт, зочны зардал	6,242.00	8,940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	223,997.20	585,037.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,481,860.30	3,000,581.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,630,932.50	1,560,835.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-792,758.00	823,715.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,019.90	1,071,932.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,019.90	1,071,932.90
2200	Дотоод эх үүсвэрээр	19,019.90	1,071,932.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,019.90	-1,071,932.90
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	811,778.00	-248,217.50
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,875,540.00	1,063,762.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,063,762.00	815,544.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,353,493.1	2,965,512.9

21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,158,493.1	2,831,168.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,858,203.6	1,678,770.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	455,392.3	389,359.0
210101	Үндсэн цалин	322,867.5	264,971.4
210102	Нэмэгдэл	128,124.8	119,448.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,400.0	3,939.0
210104	Урамшуулал	0	1,000.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,924.0	49,716.1
210201	Тэтгэврийн даатгал	39,492.1	34,290.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,156.6	3,976.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,494.7	3,189.5
210204	Ажилгүйдлийн даатгал	850.4	737.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,930.2	7,522.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	418,321.5	391,996.5
210301	Гэрэл, цахилгаан	34,503.2	24,858.8
210302	Түлш, халаалт	357,044.5	343,506.0
210303	Цэвэр, бохир ус	26,773.8	23,631.7
2104	Хангамж, бараа материалын зардал	113,950.0	112,448.2
210401	Бичиг хэрэг	10,828.6	10,798.0
210402	Тээвэр, шатахуун	79,389.1	79,269.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,765.8	4,414.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,000.0	6,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,966.5	11,966.5
2105	Номатив зардал	208.2	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208.2	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	75,630.0	75,273.4
210604	Урсгал засвар	75,630.0	75,273.4
2107	Томилолт, зочны зардал	8,914.7	8,772.0
210702	Дотоод албан томилолт	8,914.7	8,772.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	567,802.2	529,894.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	567,802.2	529,894.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161,060.7	121,310.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	142,560.7	102,810.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,500.0	18,499.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,300,289.5	1,152,398.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,279,689.5	1,132,036.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,279,689.5	1,132,036.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,600.0	20,362.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,600.0	20,362.0
2230	Хөрөнгийн зардал	195,000.0	134,344.3
223001	Бусад хөрөнгө	195,000.0	134,344.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,353,493.1	2,382,148.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	601,633.3
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	0	601,633.3
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,592,576.2	1,780,515.6
320001	Орон нутгийн төсвөөс	1,990,942.9	1,780,515.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	601,633.3	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	760,916.9	95,174.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,860.7	95,174.1
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	648,056.2	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	651,842.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	163,652.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	48	40
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4
610001	Төсвийн байгууллага	4	4
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	18
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	9	8
620003	Үйлчлэх ажилтан	7	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	18
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	8
650009	Төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ)	7	5
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,523,436.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,597,847.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,451,523.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,848.5
210101	Үндсэн цалин	3,848.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	501.5
210201	Тэтгэврийн даатгал	501.5
2104	Хангамж, бараа материалын зардал	3,571.3
210401	Бичиг хэрэг	
210402	Тээвэр, шатахуун	3,571.3
2107	Томиллолт зочны зардал	168.0
210702	Дотоод албан томиллолт	168.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,443,434.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,443,434.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	146,324.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	62,950.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	62,950.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,374.1
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	83,374.1
2210	Хөрөнгийн зардал	925,588.6
221001	Их засвар	925,588.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,523,436.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,523,436.3
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,431,185.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,504.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84,746.5

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 934,373.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 912,690.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 21,683.1 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд:

- Хөрөнгийн тайлан дахь тусламж хандиваар авсан нийт дүн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнтэй тулган баталгаажуулахад 910,252.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд элэгдлийн зардлыг 2,438.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг аудитын явцад залруулав.

Аудитаар нийт 69,111.8 мянган төгрөгийн зөрчил² илрүүлж, 4 албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгаж ажиллаагүй төсвийн төвлөрүүлэн захирагчид сахилгын шийтгэл оногдуулах тухай албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

- Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 24,700.0 мянган төгрөгийн анхан шатны баримтгүй гүйлгээг гарган зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 6.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 6.5-д "Нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус тус хяналт тавина", 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

- Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс мал эмнэлгийн 100-н жилийн ойн арга хэмжээ, санхүүчдийн баярын арга хэмжээ, төрийн албан хаагчдын зөвлөгөөний зардалд 14,293.000 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 6.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 6.5-д "Нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус тус хяналт тавина", 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

- Төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад "Тэмээн сүргийг өсгөн үржүүлэх, хамгаалах зорилгоор Говь фестивал үзэсгэлэн худалдаа, Тэмээний баярын арга хэмжээг зохион байгуулах" зардлыг төсөвлөн зарцуулсан боловч дахин засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс 8,618,800 төгрөг зарцуулсан, мөн худалдан авах гэрээ байгуулалгүйгээр 16,500.000 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 6.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.1-д "энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолын 1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1.2-д "Энэ журмын 1.1-д заасан "урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан" гэдгийг жил бүр давтагддаггүй онцгой арга хэмжээ, тохиолдлыг төсвийн зардлын зүйл, арга хэмжээний ангиллын дагуу санхүүжүүлэх боломжгүй нөхцөл байдал гэж ойлгоно", 6.5-д "Нөөц хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус тус хяналт тавина", 7.1-д "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

- Тайлант оны 4 дүгээр сард "Төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тусламж дэмжлэг үзүүлэх хөтөлбөр"-ийн зардлаас сумын ИТХ-ын ажлын албаны даргын нөхрийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөг, 8-р сард тус хөтөлбөрийн зардлаас дахин ИТХ-ын ажлын албаны даргад 2,000,000 төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "*хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Тус онд 10,751.1 мянган төгрөгөөр үл хөдлөх хөрөнгийн болон ТТАМТ-ийн орлогыг тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг хэрэгжүүлээгүй нь бүртгэлийн тоо зөрүүтэйгээс төлөвлөлтийн алдаа гарах үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж: Үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, судалгааг нарийн тооцож бодитой төлөвлөх

1.2 . Илрүүлэлт: Тайлант онд малын тоо, толгойн албан татварыг статистик тоо мэдээнд үндэслээгүй тооцоолсноос 10,932.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1"хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1"Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна",7 дугаар зүйлийн 7.1"Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ний өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө"-гэж заасантай тус тус нийцээгүй нь ИТХ-ын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэхгүй байх үр дагавартай байна.

Өгсөн зөвлөмж: Орлогыг статистик тоо мэдээнд үндэслэн бодитой төлөвлөх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах

2. Санхүүгийн нэгтгэл тайлантай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг хангаж ирүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна", санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Аудитын явцад залруулах	2	912,690.8					2	912,690.8				
Тус онд үл хөдлөх хөрөнгийн болон ТТАМТ-ийн орлогыг тасалсан	2	10,751.1									2	10,751.1
Малын тоо, толгойн албан татварыг дутуу төвлөрүүлсэн байна.	1	10,932.0									1	10,932.0
Дүн	5	934,373.9					2	912,690.8			3	21,683.1

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг гарган зарцуулсан	1	24,700.0			1	24,700.0						
Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс мал эмнэлгийн 100-н жилийн ойн арга хэмжээ, санхүүчдийн баярын арга хэмжээ, төрийн албан хаагчдын зөвлөгөөний зардалд хөрөнгө зарцуулсан	1	14,293.0			1	14,293.0						
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	25,118.8			1	25,118.8						
Нэг албан хаагчид дэмжлэг давхардуулан олгосон	1	5,000.0			1	5,000.0						
Дүн	4	69,111.8			4	69,111.8						

